

Монгол Улсын Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх техникийн хамтын ажиллагааны төсөл

Агуулга

1. Улаанбаатар хотын цахилгаан, электрон хог хаягдлын талаарх судалгааны дүн
2. Хог хаях хэв маягийг сайжруулах, ангилан ялгах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх туршилтын төслийн хэрэгжилтийн явц
3. Мэдээ мэдээлэл

Төслийн үйл ажиллагааны явцыг танилцуулдаг *Мэдээллийн тойм*-ын 4 дэх дугаарыг уншигч танд хүргэж байна. Энэ дугаарт Улаанбаатар хотын цахилгаан, электрон хог хаягдлын талаар гүйцэтгэсэн судалгааны дүн, түүнчилэн хог хаях хэв маягийг сайжруулах, ангилан ялгах үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй туршилтын төслийн хэрэгжилтийн явцыг танилцуулахаар бэлтгэлээ.

1. Улаанбаатар хотын цахилгаан, электрон хог хаягдлын талаарх судалгааны дүн

Зарим тохиолдолд “е-хаягдал” хэмээгддэг цахилгаан, электрон хог хаягдал (ЦЭХХ)-д илүүдэл, хуучирсан, эвдэрч хаягдсан цахилгаан, электрон тоног төхөөрөмжийг хамааруулж ойлгодог. ЦЭХХ-ыг устгах буюу дахин боловсруулах явцад хүний эрүүл мэнд, ялангуяа эдгээр ажиллагааг гардан гүйцэтгэж буй ажилчдын эрүүл мэнд, улмаар нийгмийн бусад давхарга, байгаль экологид ноцтой сөрөг нөлөө учруулах тул дахин боловсруулахад болон хорт элементүүдийг нь саармагжуулахдаа урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, анхааралтай гүйцэтгэх шаардлагатай.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан ЖАЙКА-гийн Зөвлөх Баг (ЖЗБ) нь Улаанбаатар хотын ЦЭХХ-ийн талаарх бодлого боловсруулахад НЗДТГ, ЗАА-нд дэмжлэг үзүүлэх зорилгоор тус хотод үүсч, хаягдаж, дахин ашиглагдаж, боловсруулагдаж буй ЦЭХХ-ын хэмжээ, эдгээр үйл ажиллагааны өнөөгийн байдлыг тодорхойлох судалгааг гүйцэтгэсэн болно.

Судалгааны зорилго

- (1) УБ хотод үүсч буй ЦЭХХ-ыг хаях, дахин ашиглах, боловсруулах, устгаж буй өнөөгийн арга хэлбэрийг тодорхойлох,
- (2) ЦЭХХ-ын хэмжээ, урсгалыг тогтоох.

Судалгааны объект, хамарсан хүрээ


Хэдийгээр 5 төрлийн цахилгаан, электрон тоног төхөөрөмж (ЦЭТТ; телевизор, хөргөгч, угаалгын машин, компьютер, гар утас)-ийг судалгааны объект болгон анхлан сонгосон боловч, гар утасны хувьд импортлогдож буй хэмжээг тогтоох боломжгүй, улмаар холбогдох урсгалыг тооцох нь хүндрэлтэй шалтгаанаар хассан болно.

Тогтолцооны өнөөгийн байдал

Судалгааны дүнгээс үзвэл УБ хот дахь ЦЭХХ-ыг

дахин ашиглах, боловсруулах, устгах арга хэлбэрүүд нь сонгогдсон ЦЭТТ-ийн төрөл бүрт үндсэндээ адил байлаа.

Дахин ашиглагдаж буй эд хэсгүүд нь гол төлөв металл агуулсан байх ба ажиллагаагүй болсон нөхцөлд металлыг нь салган борлуулдаг тул ийм төрлийн эд хэсгүүд ажиллагаатай эсэхээс үл хамааран эргэлтэнд орж байна.



Металл агуулаагүй болон хуванцар холимог материалаас бүтсэн эд хэсгийн ажиллагаатайг нь засвар үйлчилгээнд сэлбэг болгон ашиглах боломжтой боловч ашиглагдах эсэх нь тухайн төрлийн засвар үйлчилгээний онцлог, хэрэгцээнээс хамаарч байв.

ЦЭХХ-ын шат дамжлага, процесс


УБ хотод үүсч буй ЦЭХХ-ын дийлэнхийг дахин ашиглаж байгаа бөгөөд энэ нь засварын газар, хувь засварчид, зуучлан борлуулагчид хуучин ЦЭТТ-ийг худалдан авч, дийлэнхийг нь шууд борлуулах буюу засварлан борлуулдагтай холбоотой байна.



Зөвхөн засах боломжгүй ЦЭТТ-ийг задалж, эд хэсгийн зармыг нь засвар үйлчилгээнд сэлбэг болгон ашигладаг (дахин боловсруулалт).

Хөргөгчний төмөр гадрийг эс тооцвол задласан ЦЭТТ-ийн эд хэсгээс салган авсан бүх төрлийн металл (зэс, төмөр, хөнгөн цагаан, гууль, хайлш) нь түүхий эд худалдан авах цэгүүдээр дамжин БНХАУ руу экспортлогдож байв (Хөргөгчний төмөр гадрыг гэрийн зуух үйлдвэрлэгч иргэд худалдан авч, яндан болгон зах зээлд нийлүүлдэг).

Дахин ашиглах, боловсруулах ү/а-д оролцогсод



хэмжих нэгж: тн/жил

ЦЭХХ-ыг дахин ашиглах, боловсруулах үйл ажиллагаанд оролцогч субъектууд бол засварын газар, хувь засварчид, зуучлан борлуулагчид, ачигч, хог түүгч, түүхий эд авах цэгүүд байдаг.



Эдгээрээс засварын газар, хувь засварчид голлох үүргийг гүйцэтгэдэг. Энэ нь иргэдээс хэрэгцээгүй, эвдэрсэн ЦЭТТ-ийг худалдан авч зуучлан борлуулах, засч борлуулах, түүнчилэн задалж, ажиллагаатай эд хэсгийг нь засвар үйлчилгээнд ашиглах, сэлбэг болгон борлуулдаг явдал юм.

Судалгаагаар илэрсэн зүйлс

УБ хотын ЦЭХХ-ын урсгалын гол үзүүлэлтүүдийг дээрх зургаар үзүүлэв. Зургаас үзвэл нийт ЦЭХХ-ын 45.1% нь дахин ашиглагдаж, 23.0% нь дахин боловсруулагдаж (нөөцөлсөн сэлбэгийг оруулсан), 31.9% нь эцэслэн хаягддаг.

Компьютерээс бусад төрлийн ЦЭТТ-ийг дахин ашиглах хувь хэмжээ өндөр (66.9-80.2%) байгаа бол компьютерийн жингийн дийлэнхи болох CRT мониторгыг үндсэндээ ашигладаггүй тул компьютерийн дахин ашиглагдах хувь хэмжээ дөнгөж 28.6%-тай байна.



Эцэслэн хаягдаж буй ЦЭХХ-ын хэмжээ нь ЦЭХХ-ын нийт хэмжээнд 31.9%-ийг эзлэх ба хог хаягдлын хэмжээг тэдгээрийн жингээр тооцоолсон, компьютер, телевизрын тоо хэмжээ, голлон

хаягдах CRT-ийн жин их байх тул эцэслэн хаягдаж буй нийт ЦЭХХ-ын дийлэнхийг телевизор, компьютерийн эд хэсэг эзэлж байв (Компьютерийн CRT монитор 100%, телевизрын CRT дэлгэцийн 80% орчим нь эцэслэн хаягддаг. Нэг CRT 10 кг-аас илүү жинтэй тул эцэслэн хаягдаж буй ЦЭХХ (545.5 тн)-ын 94%-ийг телевизор, компьютерийн CRT эзэлдэг).

Дүгнэлт, санал

CRT-д эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлдөг мөнгөн ус зэрэг хүнд металл агуулагддаг тул тэдгээрийг аюулгүйгээр эцэслэн хаяхад голлон анхаарах шаардлагатай. Эдгээр хог хаягдалд зориулсан төвлөрсөн хогийн цэгийг тусад нь байгуулах шаардлагатай бөгөөд тэр болтол нарны гэрэл шууд тусахааргүй хуурай газар хадгалж байх нь зохистой.

Цахилгаан, электрон барааг гол төлөв гадаад улсуудаас импортолж буй учир ирээдүйд аюултай элемент агуулаагүй ЦЭТТ-ийн импортыг бодлогоор дэмжих боломжтой хэдий ч эдгээрийг өдгөө эргэлтэнд буй барааны зах зээл үнээс харьцангуй өндөр үнээр борлуулахад хүргэх магадлалтай.

ЦЭХХ-ын дахин ашиглалт, боловсруулалтыг гол төлөв хувь хүмүүс буюу засварчид, зуучлан борлуулагчид гүйцэтгэж байгаа ба тэдэнд учирч буй томоохон бэрхшээл нь хямд өртөг бүхий санхүүгийн нөөцийг бүрдүүлэх явдал болно. Иймд хотын зүгээс эдгээр иргэд албан ёсны, мэргэжлийн болж хөгжих боломжийг бүрдүүлэх нь зүйтэй бөгөөд улмаар бүртгэлжүүлэх, гүйцэтгэх ажлын хэмжээг нь тодорхойлох, ЦЭХХ-ыг хууль бусаар хаях явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэргэжүүлэхийн хамт хөнгөлттэй зээл олгох зэргээр дэмжих нь чухал байна.

2. Хог хаях хэв маягийг сайжруулах, ангилан ялгах үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх туршилтын төслийн хэрэгжилтийн явц

Туршилтын төслийн зорилго

Уг төслийн зорилго нь хог хаягдлыг ангилан хаях

үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоо, хамтын ажиллагааны түвшинг тогтоох, энэ талаарх иргэдийн мэдлэг, ухамсарыг дээшлүүлэх арга замыг тодорхойлох чиглэлээр төсөл хэрэгжүүлэгч Монголын талын боловсон хүчний чадавхийг бэхжүүлэхэд оршино.

Туршилтын төслийн тойм

2010 оны 4-р сараас Сүхбаатар дүүргийн 5 ба 7, Баянзүрх дүүргийн 1 ба 7-р хороодод уг төслийг эхлүүлсэн ба энэ нь техник, хамтын ажиллагааны төслийн хэрэгжилтийн бүхий л хугацаанд үргэлжлэх юм. Туршилтын төслийг хэрэгжүүлэх үе шатууд нь:

- Суурь судалгаа (төсөл хэрэгжих хороодын суурь мэдээллийг бүрдүүлэх)
- Иргэд, олон нийтийн мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх үйл ажиллагаа
- Явцын хяналт
- Эцсийн үнэлгээ зэрэг юм

Үүнтэй холбогдуулан ЖЗБ, ОБХХМХ, дүүргүүдийн ЗДТГ, хороод, СӨХ, тээвэрлэгч байгууллагуудын гүйцэтгэх үүргийг нарийвчлан тогтоож, мөрдөн ажиллаж байгаа болно.

Суурь судалгаа

2010 оны 5, 6-р сард хог цуглуулах үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг тогтоох, өнөөгийн хог хаях хэв маягийг тодорхойлох, түүнчилэн хог хаягдлыг боловсруулах, ангилан

ялгах тогтолцоо нэвтрүүлэх боломжийг туршин судлах зорилгоор сонгогдсон хороодын иргэд, ААНБ-уудын дунд олон нийтийн санал асуулга хэлбэрээр суурь судалгааг гүйцэтгэв. Уг судалгааг тодорхой цаг хугацаанд давтан гүйцэтгэх ба үр дүнг нь төслийн хэрэгжилтийн явцыг үнэлэхэд ашиглах юм.

Судалгааны дүн

Туршилтын төсөл хэрэгжиж хороодын нийт оршин суугчдын тал илүү хувь нь “сайн” буюу “сэтгэл ханамжтай” гэж хариулсан ба тухайн байр, орцны хог хаягдлыг хариуцсан жижүүрүүд үүргээ хангалттай гүйцэтгэдэг гэж үзжээ. Хэдийгээр өдөр бүр хогоо гарган хаядаг өрх байдаг боловч дийлэнх нь долоо хоногт 2-3 удаа хогоо хаядаг. Түүнчилэн хогоо ангилан ялгагдаггүй өрх зонхилох ба харин энэ үүргийг хогийг ачихын өмнө орцны жижүүр, ачигч нар гүйцэтгэдэг байна. Хэдий тийм боловч судалгаанд хамрагдсан иргэдийн 60 илүү хувь нь хог ангилан ялгах үйл ажиллагааг нэвтрүүлэхэд аливаа “асуудал үгүй”, нэлээд хэсэг нь “оролдоод үзье” гэж хариулсан байгаа нь хог хаягдал ангилан ялгах талаар иргэдийн хүсэл эрмэлзлэл өндөр байгааг харуулж байлаа. Ихэнх

иргэд хогоо гаргаж хаях хүртэл 2-3 хоног хадгалах боломжтой гэж хариулжээ. ААНБ-уудын хувьд, тэдний дийлэнх нь хог хаягдал цуглуулах үйлчилгээний өнөөгийн түвшинд сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн байна. Ресторан, барнаас хүнсний хог хаягдал ихээр хаягддаг бол бусад чиглэлийн ААНБ-уудаас гол төлөв цаас (картон) хаягддаг байна. Ресторан, барнууд нь шилэн лонх, хуванцар савыг гол төлөв ангилан ялгадаг бол бусад төрлийн ААНБ-уудын ангилан ялгалт хийх хүсэл эрмэлзлэл хангалтгүй байлаа.



Олон нийтийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаа, сурталчилгааны хэрэгжилт

СӨХ-дын уулзалт

2010 оны 4-р сараас эхлэн туршилтын төсөл хэрэгжиж буй хороодод ЖЗБ нь ЗАА-ны ОБХХМХ-тэй хамтран ХХҮС, дүүргийн ЗДТГ-ын ҮҮХ, тээвэрлэгч байгууллага, хорооны Засаг дарга болон СӨХ-дын төлөөлөгчдийг оролцуулсан долоо хоног



тутмын уулзалтуудыг зохион байгуулж байгаа юм. Эдгээр уулзалтуудаар оршин суугчдын хог хаях, тээвэрлэгч байгууллагын хог цуглуулах хэв маягийг тус тус сайжруулах, анхан шатны эх үүсвэр дээр хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагааг нэн тэргүүнд хэрэгжүүлэн ажиллаж байна.



Ашиглагдсан сурталчилгааны материал

Сонгогдсон хороодын хог цуглуулах үйлчилгээнд ажлын цагийн зураг авалтыг гүйцэтгэн, уг судалгааны дүнг үндэслэн тухайн хороодоос хог ачих цагийн хуваарь, түүнчилэн СӨХ-дтой хамтран хог хаях журмыг тус тус боловсруулсан болно. Улмаар СӨХ-дын уулзалтуудаар хэлэлцэж, үр дүнг харгалзан оршин суугчид, орцны жижүүрүүдэд зориулсан сурталчилгааны материалуудыг ОБХХМХ-тэй хамтран бэлтгэлээ.



Туршилтын төсөл хэрэгжүүлж байгаа хороодын нийт оршин суугчдад зориулж нийтлэг агуулга бүхий брошюр, орцны жижүүрүүд зориулж хоёрдогч түүхий эд хадгалах

шуудайг бэлтгэн тарааж, хог ачих явцад чанга яригчаар нэвтрүүлэх зорилгоор иргэдэд хандан хогоо зүй зохистой хаях тухай уриалга бүхий ая зэргийг бэлтгэж үйлчилгээнд нэвтрүүлээ.



Хэрэгжилтийн явц, хяналт

Бункер хаасан талаар

Бункертэй байранд оршин суугчид дуртай цагтаа хогоо ангилан ялгаж, уутлалгүйгээр бункерт хаядаг. Эдгээр нь бункерийн хоолойд гацаж бөглөх, хортон шавьж үржих, дулааны улиралд эвгүй үнэр тархах, зарим тохиолдолд гал гарах явдал байдаг тул бункерт хог хаядаг өнөөгийн тогтолцоо нь амьдрах орчны эрүүл ахуйд нийцэхгүй болжээ.



Бункерийн талаарх иргэдийн гомдол тасардаггүйн зэрэгцээ хогийг уутлан хаях тохиолдолд бункерт



унах замдаа задарч, улмаар удаан хугацаанд хуримтлагдсан задгай хогийг бункерээс ачихад хүндрэл учирдаг. Энэ нь хог ачих, цуглуулах

ажлын бүтээмжийг үлэмж багасгадаг тул бункертэй байрнуудын бункерийг ашиглахгүй байх зорилтыг дэвшүүлсэн юм. Өөрөөр хэлбэл хог хаягдлыг эрүүл ахуйн



шаардлагад нийцүүлэн ачиж, цуглуулах явдал бөгөөд үүний тулд эх үүсвэрүүдээс хог гаргаж хаях цаг, тэдгээрийг ачих цагийг ойртуулан богиносгох шаардлагатай болно. Өөрөөр хэлбэл нэг талаас хогны машин тогтмол цагт, тогтоосон хуваарийн дагуу ирж ачих, нөгөө талаас оршин суугчид тогтоосон цэгт, тогтсон цагт хогоо гаргаж тавьдаг болгон хэвшүүлэх шаардлагатай юм.

Дээрх зорилтыг СӨХ-дын уулзалтуудаар танилцуулж, улмаар сонгогдсон байрнуудыг хариуцаж буй СӨХ-дын дарга нартай зөвлөлдөн тэдний шийдвэрийг үндэслэн бункеруудыг хаасан болно. СӨХ-д нь бункерийн амыг наалддаг тууз ашиглан нээх боломжгүй болгосон ба ЖЗБ-ийн зүгээс ЖАЙКА, Улаанбаатар хотын төр захиргааны байгууллагын лого бүхий ухуулга хуудсыг урьдчилан бэлтгэж бункерын аманд наасан юм.

Энэхүү ажил нь бункертэй байрны тоогоороо тэргүүлж буй СБД-ийн 7-р хороонд илүү үр дүнтэй хэрэгжсэн байна. Түүнчилэн тус хорооны хог ачих үйлчилгээг цагийн хуваарийн дагуу гүйцэтгэдэггүй,

зөвхөн хог ихээр хуримтлагдсан эх үүсвэрүүдээс эхлэн цуглуулдаг байсан бол ЖЗБ-ийн зүгээс эх үүсвэр бүрээс хог ачиж, цуглуулах үйлчилгээний цагийн хуваарийг боловсруулан оршин суугчдад



танилцуулж, улмаар хогоо тогтоосон цаг, газарт зүй зохистой хаях журам, эх үүсвэр дээр ангилан ялгах үйл ажиллагааг дэмжин оролцохыг

СӨХ-дтой хамтран уриалж ажилласны дүнд тус хорооны нөхцөл байдал эрс сайжирчээ.



Бункер хаах ажлыг эхний ээлжинд дэмжин зөвшөөрсөн

СӨХ-д бункерээс татгалзах зорилтыг амжилттай хэрэгжүүлсэн нь энэхүү туршлагыг бусад байранд үр дүнтэй нэвтрүүлэх үндсэн нөхцөл болсон юм. Хог цуглуулах үйлчилгээний явцад нэг цэгээс хог ачихад зарцуулах хугацаа хамгийн ихдээ 2 цаг байсан бол одоо хамгийн багадаа 2 минут болсон байна.

Жижүүрүүдийн ангилан ялгасан хогны хэмжэ

Эх үүсвэр дээр хог ангилан ялгах үйл ажиллагааны хэрэгжилтийг тогтоох зорилгоор жижүүрүүдийн цуглуулж, борлуулсан хоёрдогч түүхий эдийн хэмжээг тооцож байгаа болно. Уг тооцоонд ашиглах үндсэн мэдээллийг дараах 3 аргаар бүрдүүлж байна. (1) Орцны жижүүрүүд нь хоёрдогч түүхий эдийг цуглуулж, борлуулах бүртээ урьдчилан бэлтгэж тараасан маягтын дагуу бүрдүүлсэн бүртгэлийн мэдээ, (2) БЗД-ийн 1-р хороонд Бямба гариг бүрт гүйцэтгэж буй хоёрдогч түүхий эдийг ангилан цуглуулах үйлчилгээний явцад цуглуулсан хоёрдогч түүхий эдийн бүртгэлийн мэдээ, (3) СБД-ийн 7-р хорооны 5а байранд үйл ажиллагаа явуулж буй түүхий эд авах цэгийн худалдан авалтын мэдээ зэрэг юм.

Хог хаях хэв маяг, ангилан ялгах үйл ажиллагаа, түүний ач холбогдлыг иргэдэд сурталчилж эхлээд удаагүй тул дахин ашиглагдах хог хаягдлын хэмжээ өссөн гэж үзэх нь учир дутагдалтай. Уг ажлын үр дүнг бодитой үнэлэхэд тодорхой хугацаа шаардлагатай болно.

3. Мэдээ, мэдээлэл

- СӨХ-ийн уулзалтууд: 10-р сард эхлэх
- Жижүүрүүдийн ангилан цуглуулж буй түүхий эдийн мониторинг
- СБД-ийн 7-р хорооны хог тээврийн үйлчилгээний графикийн биелэлтэд тавих хяналт
- ЧД-ийн 12-р хорооны суурь мэдээллийг бүрдүүлэх

УБ хотын хатуу хог хаягдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх техникийн хамтын ажиллагааны төслийн ЖАЙКА-ийн зөвлөх баг
[Ажлын байрны хаяг]
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо,
Г.Бумцэнд-68, Хот тохижилтын газрын байр
Утас: 327128, Факс: 323128
Вэб хуудас: <http://www.kkcub.mn/>